

## "АПУ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4-р сарын 30-ны өдрийн 14 цаг 02 минутад эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын [www.agm.mn](http://www.agm.mn) програм хангамжийн тусламжтай, Лайвстрийм ХХК-ийн шууд дамжуулалтаар явуулав.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчидтэй мэндчилэн, хурлын хөтөлбөр, дэгийг танилцуулаад хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй зочдыг танилцуулав.

Хуралд биечлэн оролцсон:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга Ё.Гэрэлчулуун
3. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга О.Одбаяр
4. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Үнэнбат (цахимаар)
5. Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг
6. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Гомбо-Эрдэнэ
7. Хөндлөнгийн аудитор Солид Юнити Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Мөнхтогтох
8. Хөндлөнгийн аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн төлөөлөл Татьяна Яковлева
9. Хөндлөнгийн аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн төлөөлөл Б.Гэрэл
10. Хөндлөнгийн аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн төлөөлөл Cho Sang-Yong

Хурлын нарийн бичгийн дарга:

1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан

Хурлын дэгийн дагуу хурлын бүртгэлийн ажиллагааны дүнг гаргаж, ирцийн мэдээ танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Б.Ононг хурлын индэрт урив.

### Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Б.Ононгийн танилцуулснаар:

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, "АПУ" ХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсэг болон "АПУ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн 937,370,019 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 100 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 1,064,181,553 ширхэг энгийн хувьцааны 88.08% болж байгааг хуралд оролцогч болон хурлын даргад мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцов.

Ирц бүрдсэн тул Компанийн гүйцэтгэх захирал, хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хурлыг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

### Хэлэлцэх асуудал:

1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох,
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох,
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.

#### **Хэлэлцсэн нь:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

#### **Танилцуулсан нь:**

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахдаа дараах зүйлсийг онцлов. Үүнд:

- Томоохон хөрөнгө оруулалтаас дурдвал: “Спирт бал бурам” үйлдвэрт Монгол бяслаг, Шигүдэри брэнд урлах үйлдвэрийг бүтээн байгуулж, ашиглалтад оруулсан, “Монгол сарлаг” төслийг амжилттай хэрэгжүүлж “Mont Yak” брэндийг нэвтрүүлсэн, Улаанбаатарын баруун бүсийн агуулахыг шинээр ашиглалтад оруулж түгжрэл, нүүрсхүчлийн хийг багасгахад хувь нэмрээ орууллаа.
- Компанийн 100 жилийн ойн босгон дээр эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ дэлхийн алдарт Publicis зөвлөх группийн тусламжтай шинэчилсэн.
- Цэвэр борлуулалтын орлогыг өмнөх оноос 30%-аар өсгөж 1.1 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн бол цэвэр ашиг 117 тэрбум байлаа. Цэвэр ашгийн бууралтад Дижитал Концепт ХХК-ийн алдагдал голлон нөлөөлсөн. Борлуулалтын тоо хэмжээг 8%, татвар төлөлтийг 10%-аар тус тус өсгөж, улсын төсөвт нийт 438 тэрбум төгрөгийн татвар төлөв.
- Нийт 513 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүтээгдэхүүний нэр төрлийг 15%-аар нэмэгдүүлсэн бол ажилтны тоо 18%-аар өсөж 300 гаруй ажлын байр шинээр бий болголоо.
- Шунхлай группээс нийт 7500 ажилтандаа Компанийн хувьцааг эзэмшүүлэв.
- Хүн төвтэй засаглалын бодлогыг хэрэгжүүлж, ажилтанд чиглэсэн олон үйл ажиллагааг зохион байгуулж, урамшууллын шинэ тогтолцоог бий болгов.
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд онцгой анхаарч хатуулаг багатай бүтээгдэхүүнүүдийг шинээр нэвтрүүлж, архи, шар айргийн хатуулгийг багасгалаа.
- Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх стратегийг боловсруулж, ТУЗ-өөр батлуулахад бэлэн болсон.
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн хянан баталгаажсан үнэлгээгээр “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдэж, нээлттэй хувьцаат компаниудаас дөрөвдүгээр байранд эрэмбэлэгдэж байна.
- Ногдол ашгийг жилд хоёр удаа, тогтмол хуваарилж байгаа ба өнгөрөгч онд 95 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ олгосон. 2023 оны хоёрдугаар хагас жилийн үр дүнгээс хуваарилсан ногдол ашгийг өнөөдөр “ҮЦТХТ” рүү шилжүүлсэн.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2023 оны ажлын товч тайлан, 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав. Үүнд:

- ТУЗ нь Компанийн ТУЗ-ийн болон охин, хараат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, үүрэг хариуцлагыг хэрэгжүүлдэг ба 2023 онд нийт 14 удаа хуралдаж 55 тогтоол шийдвэр гаргалаа.

- ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 3 удаа, нэр дэвшүүлэх хороо 1 удаа, цалин урамшууллын хороо 1 удаа тус тус хуралдаж, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал, дүгнэлт, шийдвэр гаргав.
- ТУЗ-өөс 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “АПУ групп компани 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” хэмээн дүгнэсэн.

#### Асуулт хариулт:

##### 1. Хувьцаа эзэмшигч Алтан-Оч:

- Хуралд оролцож, саналаа өгөөд гарын бэлгээ авах хүсэлтэй байна.

##### 2. Хувьцаа эзэмшигч Цэцгээ:

- Цахим технологийн чадвар муутай, өндөр настай хувьцаа эзэмшигчдээ танхимаар хүлээж авах, цахим, танхим хослуулж хуралдах нь зөв. Өмнө танхимаар хүлээж авч, олон хүн баярлуулдаг байсан жишгээ сэргээж өгнө үү.

##### 3. Хувьцаа эзэмшигч Эрдэнэтуяа:

- Ирэх жилийн хурлыг заал, цахимаар хослуулж хийж болох уу?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэхийн хэрээр танхимаар хуралдахад хүндрэлтэй болж байгаа тул хүртээмжтэй байлгах үүднээс цахимаар хуралдаж байна. Гарын бэлгийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр 20 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг болгон хүлээн авч, үйлдвэртэй танилцуулдаг шинэ соёлыг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа тул бэлэг өгөхгүй байхаар шийдвэрлэсэн.

##### 4. Хувьцаа эзэмшигч Оюунсайхан:

- Экспортын борлуулалт нийт борлуулалтын хэдэн хувийг эзэлж байна вэ? 2023 онд хэр их өссөн, 2024 онд хэр өсөх хандлагатай байна? 2023 оны борлуулалт 30% өссөн байна. Эдгээр өсөлтийн гол хүчин зүйлс юу вэ? 2024 онд хэр хэмжээний өсөх боломжтой вэ? 2024 онд ногдол ашиг нэмэгдүүлэх боломж байгаа юу, хэр их нэмэх боломжтой вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Урд хойд 2 хөрш улс дахь борлуулалт эргэн сэргэж байна. Өмнөх онд ОХУ-ын борлуулалт 50% орчим нэмэгдсэн бол ирэх онд мөн 50%-аар нэмэгдэх хүлээлттэй байна. Экспортын борлуулалтын тоо хэмжээ, үнийн дүнгийн хувьд нийт борлуулалтад бодитой том нөлөөлөхүйц хэмжээнд хүрээгүй байна. Дотоодын борлуулалт өсөхөд нөлөөлсөн голлох хүчин зүйлд 1. Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого 30%-аар өссөн, 2. Тэрэлж, Сэлэнгэ, Оргилуун зэрэг ус ундааны бизнес 80%-аар өссөн, 3. Архи, шар айргийн хатуулгийг багасгаж, шинэ бүтээгдэхүүнүүд болон Монголын зах зээлд шууд уух зориулалттай коктейлийг нэвтрүүлснээр орлогыг 30% орчим өсгөсөн зэргийг дурдаж болно.

##### 5. Хувьцаа эзэмшигч Эрдэнэ:

- Үйлдвэрийн хэтийн зорилго юу вэ? Үйл ажиллагаагаа өргөтгөх боломжтой юу?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Бид тогтвортой хөгжлийн “Бахархалт Монгол” стратегийн голлох багануудыг танилцуулсан. 2024 онд цөөн хэдэн зорилт тавьж байгаа нь борлуулалтын орлого ашгийг өсгөх (segmented P&L дата хөгжүүлэх төсөл), процессыг

хялбарчлах буюу сайжруулах (ESSA төсөл), ажилтны гүйцэтгэлийн удирдлага, цалин хөлсний тогтолцоог шинэчлэх ажлуудыг хэрэгжүүлснээр үр дүнгээ ойрын 2-3 жилд өгнө хэмээн итгэж байна. Хөрөнгө оруулалтын хувьд сүүний бизнесийг өргөтгөх төсөл хэрэгжиж байгаа, 2026 онд сүүний үйлдвэрийн хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, хүний эрүүл мэндийг дэмждэг эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг түлхүү үйлдвэрлэхээр ажиллаж байна.

6. Хувьцаа эзэмшигч Нямдаваа, Хүрэлбаатар, Лхагвасүрэн:

- Хувьцааны ханш ихээхэн унаж байна. Шалтгаан юу вэ? Цаашид ямар арга хэмжээ төлөвлөж байна вэ?
- Ногдол ашиг төлөх хугацааг тодорхой заах хэрэгтэй байна.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

- Компани жилд хоёр удаа ногдол ашиг хуваарилж байна. СЗХ-ноос жилийн эцсийн ногдол ашгийг 4-р сарын 30-ны дотор төлөхийг даалгасны дагуу өнөөдөр бид ногдол ашгаа төлж байна, цаашдаа ч энэ хугацааг баримтална гэж бодож байна.
- Хувьцааны ханшийн тухайд хөрөнгийн зах зээлд эргэлдэж буй хөрөнгө хязгаартай, ялангуяа банкуудын хувьцаанд хөрөнгө оруулалт ихээхэн хийгдэж байна. Бидний зүгээс хийх зүйл бол үйл ажиллагаагаа сайжруулах, борлуулалт, ашиг орлогоо нэмэгдүүлэх, улмаар ногдол ашгаа өсгөх арга хэмжээ авч байна. Бид цэвэр ашгийн 80-аас дээш хувийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ олгож байгаа нь сүүлийн таван жилд уламжлал болсон төдийгүй бидний хариуцлага болжээ.

**Хэлэлцсэн нь:**

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох

**Танилцуулсан нь:**

ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Одбаяр ТУЗ-ийн гишүүн Сергей Громов, Доржийн Миеэгомбо нар чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул үүрэгт ажлаас чөлөөлж, шинэ гишүүдийг сонгох шаардлага үүссэн тул ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь бүрэн эрхийг дуусгавар болгохоор болсныг танилцуулав.

**Хэлэлцсэн нь:**

3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

**Танилцуулсан нь:**

ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Одбаяр Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн ердийн гишүүнд П.Батсайхан, Б.Батбаяр, Кеннет Чу, Сэн И-Ин, Б.Гантиг, Б.Гомбо-Эрдэнэ, хараат бус гишүүнд Ё.Гэрэлчулуун, О.Одбаяр, Ж.Үнэнбат нарыг нэр дэвшүүлсэн ба шинээр нэр дэвшиж буй Батсайханы Гантиг, Баярцогтын Гомбо-Эрдэнэ нарыг танилцуулав. Үүнд:

- Батсайханы Гантиг: АНУ-ын Пепердайн (Pepperdine) их сургуулийг Бизнесийн удирдлага, менежмент мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 2010-2016 онд Монголбанкнд дотоод аудитор, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, ерөнхийлөгчийн туслахаар, 2018-2023 онд АПУ ХК-д төслийн удирдагч, стратеги эрхэлсэн захирлаар ажилласан байсан, 2020 оноос одоог хүртэл Дижитал концепт ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

- Баярцогтын Гомбо-Эрдэнэ: АНУ-ын Виржиниагийн их сургуулийг Хэрэглээний математик, эдийн засаг мэргэжлээр бакалавр, БНХАУ-ын Олон улсын бизнес, эдийн засгийн их сургуулийг Санхүү удирдлага мэргэжлээр бакалавр зэрэгтэй дүүргэсэн. 2011-2012 онд Сангийн яаманд Сайдын туслах, 2011-2014 онд Спарк солюшнс ХХК-д санхүү хариуцсан захирал, 2017-2021 онд Голомт банкинд Картын хэлтсийн захирлаар ажиллаж байсан, 2021 оноос одоог хүртэл Шунхлай холдинг ХХК-д Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажиллаж байна.

**Асуулт хариулт:**

- Байсангүй.

**Хэлэлцсэн нь:**

4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах

**Танилцуулсан нь:**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан Компанийн засаглалын кодексийн 6-р зарчмын 6.1-д “ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батална” гэж заасны дагуу энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн татвар, суутгал хасаагүй үндсэн цалинг өмнөх оныхоос өөрчлөлтгүйгээр буюу ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая, сар бүр мөнгөн хэлбэрээр олгож, нэмэлт урамшуулал, хөлс олгохгүй байхаар батлуулах санал оруулж буйг танилцуулав.

**Асуулт хариулт:**

- Байсангүй.

Тооллогын комиссын дарга Б.Онон санал өгөх зааврыг танилцуулж, санал хураалт эхэлснийг мэдэгдэв.

Санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга Б.Онон санал хураалтын дүнг танилцуулахдаа:

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
931,027,585.00	99.9999%	0.00	0.00%	800.00	0.0001%

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
931,024,713.00	99.9996%	3,642.00	0.0004%	30.00	0.000003%

3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
931,027,563.00	99.9999%	22.00	0.000002%	800.00	0.000009%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

**1. ТУЗ-ийн гишүүдийг сонгох:**

**Ердийн гишүүдэд өгсөн санал:**

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Пүрэвийн Батсайхан	9.87%	826,942,830
2	Бүрэнтогтохын Батбаяр	9.87%	826,813,460
3	Кеннет Чу	15.90%	1,332,644,763
4	Сэн И-Ин	15.01%	1,257,580,961
5	Батсайханы Гантиг	9.87%	826,873,437
6	Баярцогтын Гомбо-Эрдэнэ	9.87%	826,805,482

**Хараат бус гишүүдэд өгсөн санал:**

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ёндон-Ойдовын Гэрэлчулуун	9.87%	826,812,525
2	Одончимэдийн Одбаяр	9.87%	826,809,562
3	Жигжидийн Үнэнбат	9.88%	827,972,445

тус тус санал авч эдгээр 9 гишүүн ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын шийдвэрийг танилцуулж, хурлыг хаана уу хэмээн хурлын дарга Ц.Эрдэнэбилэгийг индэрт урив. Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг ТУЗ-д шинээр сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, амжилт хүсээд ТУЗ-ийн гишүүнээр олон жил үр бүтээлтэй ажиллаж, Компанийг удирдан чиглүүлж байсан Сергей Громов, Д.Миеэгомбо нарт талархсанаа илэрхийлж, сайн сайхныг хүсэв.

**Хурлын шийдвэр:**

1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан доорх дүгнэлтийг батлав.
  - 1.1. АПУ групп компани 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан.
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов.

**Ердийн гишүүн**

1. Пүрэвийн Батсайхан
2. Бүрэнтогтохын Батбаяр
3. Кеннет Чу
4. Сэн И-Ин
5. Батсайханы Гантиг
6. Баярцогтын Гомбо-Эрдэнэ

**Хараат бус гишүүн**

1. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
  2. Одончимэдийн Одбаяр
  3. Жигжидийн Үнэнбат
4. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг батлав.

Тэрбээр Монгол Улсад анх удаа дэлхийн шилдэг брэнд Хайнекен шар айргийг үйлдвэрлэж эхэлж байгаа нь 100 жилийн түүхт АПУ үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж, стандарт дэлхийн хэмжээнд хүрснийг баталсан үйл явдал болж буйг онцлон тэмдэглээд хурлыг хаав.

Хурал 15 цаг 33 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
нарийн бичгийн дарга



Ч.Ариунсан

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ц.Эрдэнэбилэг